



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 01 дугаар
сарын 10 өдөр

Дугаар 4-03

Улаанбаатар
хот

Нийслэлийн "Цэрэг,иргэний хамгаалалтын
штаб"-ыг байгуулах тухай

Нэг. Монгол улсын Засгийн газрын "Цэрэг,иргэний хамгаалалтын талаар авах арга хэмжээний тухай" 1999 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн, Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй хэрэгжүүлэгч агентлаг "Цэрэг,иргэний хамгаалалтын штаб"-ыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга, хурандаа Л.Доржсүрэнг 1999 сны 12 дугаар сарын 31-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, 2000 оны 1 дүгээр сарын 1-нээс Нийслэлийн "Цэрэг,иргэний хамгаалалтын штаб"-ын даргаар томилсугай.

Гурав. Зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан Цэрэг,иргэний хамгаалалтын штабын 10 орон тоог, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн орон тооноос хасаж тооцохыг Тамгын газар \Ц.Болдсайхан\, штабын 2000 оны төсвийн асуудлыг авч үзэхийг Санхүүгийн хэлтэс \Д.Гонгор\ -т даалгасугай.

Дөрөв. Уг захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны "Нийслэлийн Цэрэг,иргэний хамгаалалтын штабын тухай" б\ 119 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2000 оны 4-03
захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЦЭРЭГ, ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ШТАБЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штаб / цаашид "штаб" гэх / нь Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг орон нутагт хангах ажлыг тайван болон онцгой нөхцлийн үед зохион байгуулах, хэрэгжүүлэх нийслэлийн ард иргэдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг нэгтгэн төлөвлөж, тодотгох, бэлтгэл, бэлэн байдлыг нь хангуулах, энэ чиглэлээр мэргэшил, арга зүйн удирдлага туслалцаа үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллага мөн. Штаб нь Нийслэлийн Байнгын Онцгой комиссын өдөр тутмын ажлыг эрхлэнэ.

2. Штабын үйл ажиллагаа нь дараахь үндсэн зорилтыг хэрэгжүүгэхэд оршино:

а/ Батлан хамгаалах талаархи бодлого хууль, тогтоомжийг биелүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтэнд нь хяналт тавих

б/ хуульд заагдсан удирдлага, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

в/ цэргийн болон иргэний хамгаалалтын дайчилгааны даалгаварыг төлөвлөх, тодотгох, бэлэн байдлыг хангуулах

г/ Цэрэг техникийн тоо бүртгэл хөтлөх

д/ Цэрэг халалт, татлага дүйцүүлэх албаны үйл ажиллагааг зохион байгуулах, орон нутгийн цэргийг удирдах.

е/ нутаг дэвсгэртээ байрлаж байгаа Зэвсэгт Хүчин, бусад цэргийн анги байгууллагатай хамтран ажиллах

ж/ Хөнөөх хэрэгсэл, байгалын болон бусад гамшиг, ослос урьдчилан сэргийлэх, хамгаалах, аврах, тэмцэх, хор уршгийг арилгах арга ажиллагаанд бүх нийтийг сургаж бэлтгэх, энэ арга ажиллагааг удирдан зохион байгуулах.

3. Штаб нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хууль, тогтоомж улсын болон нийслэлийн Байнгын Онцгой Комисс, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тушаал, Нийслэлийн Засаг даргын захирамж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

4. Штабт орон нутаг дахь батлан хамгаалах салбарын харъяалалтай байгууллагууд /цэргийн ангиас бусад /, цэргийн албан хаагчид цэргийн албаны хувьд захирагдана.

5. Штаб нь Нийслэлийн Иргэдийн хурлаас баталсан төсөв, Засгийн газар, Улсын болон нийслэлийн Байнгын онцгой комиссын бэлтгэл сан, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэлийн төсвөөс хуваарилагдсан гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, сэргээн босгох арга хэмжээний болон цэрэг татлага, сургалт бэлтгэл, бэлэн байдлын зардал, хандивын хөрөнгийг тогтоосон журмын дагуу зарцуулна.

6. Штаб нь нийслэлийн хэмжээнд цэргийн болон иргэний хамгаалалтын дайчилгаа явуулах, гамшиг-ослын тухай дуудлага болон үйлдвэрлэл, үйлчилгээний журам зөрчигдсөн тохиолдолд нийслэл, дүүргүүдийн удирдлага, албан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчид, ард иргэдэд зарлан мэдээлэлийг хүргэх, авран хамгаалах ажлыг шуурхай авч хэрэгжүүлэх үүрэг бүхий "Шуурхай мэдээлэлийн төв"-ийг байнгын жижүүрлэлттэй ажиллуулна.

7. Штабын шууд удирдлаганд Байгалийн гамшигаас аврах анги, бусад томилгоот орон тооны бус хүч хэрэгсэл байна.

8. Штабт нийслэлийн удирдлага, цэрэг, иргэний хамгаалалтын арга хэмжээг удирдах, урьдчилан томилгоожуулан төхөөрөмжлөгдсөн шаардлага хангасан, хотын гаднах удирдлагын байртай байж болно.

9. Штаб нь зохих журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Штабын удирдлага, зохион байгуулалт

10. Штаб нь Нийслэлийн Засаг даргын шууд удирдлагын дор үйл ажиллагаа явуулна.

11. Штаб нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Засаг даргаас захиргааны удирдлагаар, цэргийн удирдлагын байгууллагуудаас мэргэжлийн удирдлагаар хангагдана.

12. Штабын дарга бусад ажилтнуудыг дор дурьдсанаар томилж, чөлөөлнө.

А / даргыг батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг дарга нар зөвшилцөн, Батлан хамгаалахын сайдын тушаал, Нийслэлийн Засаг даргын захирамжаар.

Б / бусад ажилтнуудыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг үндэслэн, штабын даргын тушаалаар.

13. Штабын дарга нь дотоод ажлын төлөвлөлт, зохион байгуулалттай холбогдсон асуудлаар шийдвэр гаргаж, штабын ажилтнуудыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар хангана.

14. Штабын дарга нь нийслэлийн Байнгын онцгой комиссын дарга байх бөгөөд Засаг даргад батлан хамгаалах асуудал, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дэмжлэг үзүүлж Байнгын онцгой комиссын өдөр дутамын үйл ажиллагааг удирдана.

Гурав. Штабын эрх, үүрэг

15. Штаб дор дурьдсан эрхтэй байна

а/ Хуульд заагдсан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийн дагуу хүн техникийг засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн эрх баригч, иргэдэд хуулиар хүлээсэн үүрэгтэй нь уялдуулан оногдуулан данслах, тодотгох, бэлэн байдлыг хангуулах харилцааг хэрэгжүүлэх асуудлаар биелэлтийг нь дүүргийн Засаг даргаар гаргуулан авах.

б/ Дүүргийн дайчилгааны болон иргэний хамгаалалтын удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг хянаж, дүгнэлт гаргаж, баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх

в/ Шаардлагтай тайлан мэдээг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудаас гаргуулан авах

г/ Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад харъяалал харгалзахгүйгээр батлан хамгаалах асуудалтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар үүрэг, чиглэл өгч, биелэлтийг хангуулах.

д/ Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цэргийн жинхэнэ алба хаагчийн чөлөө, томилолтын хугацааг 7 хүртэл хоногоор сунгах.

е/ Цэрэг иргэний хамгаалалтынүйл ажиллагаанд идэвхи зүтгэлтэй оролцсон аж ахуйн нэгж, байгууллага, цэргийн үүрэгтэн, иргэдийг шагнаж урамшуулахаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллагад тодорхойлох.

ж/ Улсын ба цэргийн дайчилгаа, сургууль цугларалт, цэргийн тоо бүртгэл, татлагаас зайлсхийсэн хүмүүс, тэднийг үүргээ биелүүлэхэд нь саад учруулсан албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх.

16. Штаб нь дор дурьдсан үүрэгтэй байна.

а/ Батлан хамгаалах салбарын талаархи бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах.

б/ хууль тогтоомжид заасан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг бсловсруулан Засаг даргатайгаа зөвшилцсөний үндсэн дээр эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих,

в/ Монгол улсын Засгийн газрын "Цэргийн болон иргэний хамгаалалтын дайчилгааны даалгавар"-ыг нийслэлийн дүүрэг байгууллага, аж

ахуйн нэгж иргэдэд хуваарилан оногдуулан данслаж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад нь туслан биелэлтэнд нь хяналт тавина.

г/ эрх бүхий байгууллагын шийдвэр, Засаг даргын захирамжийн дагуу иргэдийг жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, халах, цэрэг-техникийн шинэчилсэн бүртгэл явуулах ажлыг зохион байгуулах, дайчилгааны даалгаврыг хангах бүх талын арга хэмжээ авах,

д/ иргэний хамгаалалтын арга хэмжээг нийслэлийн хэмжээнд төлөвлөн зохион байгуулж, хяналт тавих, оперативын бэлтгэлийн явц, төлөвлөлт, биелэлтэд дүгнэлт хийж боловсронгуй болгох, байгалийн болон бусад гамшиг ослоос сэргийлэх, тэмцэх, хамгаалах, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг удирдах, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх,

е/ дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагаас цэргийн болон иргэний хамгаалалтын сургалт, дадлагад оролцох хүн, техникийг тодорхойлох, үүнтэй холбогдсон төлөвлөгөө хийхэд туслас, зарлан мэдээллийг хүргэх,

ж/ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, учирсан хор хохирлыг арилгахад татан оролцуулах, мэргэжлийн байгууллагад туслас үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,

з/ цэргийн сургуульд суралцах, анги салбарт гэрээгээр алба хаах хүсэлтээ илэрхийлсэн иргэдийг судлах, үзлэг, шалгаруулалтад оруулах, элсүүлэх.

и/ эрхэлсэн ажлын чиглэлээр Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн удирдлагын байгууллага, Засаг даргаас өгсөн үүргийг биелүүлэх ажлыг зохион байгуулах, Засаг даргад мэргэжлийн зөвлөлгөө өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх,

к/ Батлан хамгаалахын сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих,

л/ цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдыг сургах, алба хаалгах, тэдэнтэй холбогдсон асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,

м/ цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаагчдын бүртгэлийг хөтөн төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулах,

н/ цэргийн бэлтгэл үүрэгтэнг давтан сургах, цэргийн дүйцүүлэх алба, иргэний хамгаалалтын үйл ажиллагааг явуулахтай холбогдсон зардлын нэгдсэн тооцоог гаргаж, орон нутгийн төсөвт тусгуулахаар нийслэлийн Засаг даргад уламжлах,

о/ амралт, чөлөөгөөр болон томилолтоор, орон нутагт яваа цэргийн жинхэнэ албан хаагчийг бүртгэн, чөлөөний хуудас, томилолтод тэмдэглэл хийх,

п/ нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт байгаа цэргийн үүрэгтний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг барагдуулах,

р/ нийслэлийн шуурхай мэдээллийн төв, байгалийн гамшигаас аврах ангийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган, байнгын онцгой комиссын

- ажлыг зохион байгуулахад Засаг даргад дэмжлэг үзүүлэх, өдөр дутамын үйл ажиллагааг хангах

с/ цэрэг-иргэний хамгаалалтын ажлын мэдээ, тайланг тогтоосон журмаар гарган батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын холбогдох төв байгууллагад явуулах, илтгэх.